



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 94

Номгон

“Хонгор орд майнинг” ХХК-ний үйл  
ажиллагааг дэмжиж, хувь эзэмших тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар 16.2, 62 дугаар зүйлийн 62.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 78 дугаар зүйлийн 78.2.38, “Хонгор орд майнинг” ХХК-ний хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хонгор орд майнинг” ХХК-ний эзэмшлийн 20 хувийг аймагт өгөх саналыг зохих хууль, тогтоомжийн дагуу судалж үнэ төлбөргүйгээр шилжүүлэх, цаашид хамтран ажиллахаар ирүүлсэн саналыг дэмжсүгэй.
2. Орон нутгийн өмчийн оролцооны хувь хэмжээ хариуцсан албан ёсны төлөөлөгчөөр Баянхонгор Нью майнинг орон нутгийн өмчит ХХК-ийг томилсугай.
3. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

3.1 “Хонгор орд майнинг” ХХК-ийг орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж болгон зохион байгуулж, ажлын хэсэг гаргаж хуулийн хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласугай.

3.2 Орон нутгийн өмчийн оролцоотой “Хонгор орд майнинг” ХХК-д Уул уурхайн сайдын 2015 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулах журам”-ын 1.6 дахь заалтын дагуу хязгаарлагдмал сонгон шалгаруулалтад давуу эрхтэй оролцуулах, хайгуулын тусгай зөвшөөрөл олгуулах саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт уламжилсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117237